Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 5 дугаар сарын 20-ний өдрийн 17-р тогтоолоор байгуулагдсан сумын өмч хамгаалах байнгын зөвлөл тус сумын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж төсвийн

хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгөд хяналт тавин ИТХ-ийн хуралдаанаар тогтоол гаргуулан өмч хөрөнгийг бүртгэлд тусгуулж, актлах хөрөнгийг шийдвэрийн дагуу устгах ажлыг хариуцан ажиллаж жилийн ажлыг 88.7 хувьтай дүгнүүлсэн байна.

Мөнххайрхан сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,455.2 сая төгрөгөөр буюу 40 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	290	159.7	130.3	0.6
Авлага	148.1	109.9	38.2	0.7
Урьдчилгаа	60.3	196.4	-136.1	3.3
Бараа материал	289.9	41.3	248.6	0.1
Үндсэн хөрөнгө	6521.1	2346.9	4,174.2	0.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7309.4	2854.2	4,455.2	0.4
Богино хугацаат өр төлбөр	9.6	12.7	-3.1	1.3
Цэвэр хөрөнгө, өмч	7299.8	2841.5	4,458.3	0.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7309.4	2854.2	4,455.2	0.4

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 290.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 159.7 сая төгрөг болж 130.3 сая төгрөгөөр буюу 45 хувиар буурсан байна. Аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулсантай холбоотой урьд оны давсан орлогыг сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн санхүүгийн дэмжлэгт хуваарилсантай холбоотой буурсан байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 109.9 сая төгрөг болж, өмнөх оноос 38.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	13.00	-	(13.0)
Хувь хүмүүсээс авах авлага	135.10	109.9	(25.2)
Дүн	148.1	109.9	(38.2)

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 38.2 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангаас нэмж зээл гаргаагүй 28.7 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулсан, Улсын төсвийн байгууллагуудын балансыг шилжүүлсэнтэй холбоотой Ерөнхий боловсролын сургуулийн балансад бүртгэлтэй 13.0 сая төгрөгийн авлага шилжиж барагдуулсантай холбоотой өөрчлөгдсөн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 196.4 сая төгрөг болж, өмнөх оноос 136.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	10.4	146.5	136.1
Тусгай зориулалтын сан	49.9	49.9	-
Дүн	60.3	196.4	136.1

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнххайрхан сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар “Ёслол хүндэтгэлийн өргөө барих” НШТ-2022-Ажил-02 дугаартай гэрээний дагуу 136.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгож тухайн ажлыг улсын комисс хүлээж аваагүй урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 31.3 сая төгрөг болж 258.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Түүхий эд материал	289.9	31.3	-258.6	
Тусгай зориулалттай материал	3.17	0.00	3.2	0.0
Эм боох материал	53.75	0.00	53.8	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	15.19	9.17	6.0	0.6
Хангамжийн материал	217.8	22.12	195.7	0.1
Бичиг хэргийн материал	4.02	1.31	2.7	0.3
Аж ахуйн материал	39.7	18.20	21.5	0.5
сэлбэг хэрэгсэл	0.34	0.34	0.0	1.0
Түлш шатах тослох материал	1.3	0.00	1.3	0.0
Барилгын засварын материал	12.69	2.27	10.4	0.2
Хүнсний материал	15.89	0.00	15.9	0.0
Бусад хангамжийн материал	143.86	0.00	143.9	0.0
Нөөцийн бараа	0	10.01	-10.0	1.0
Нийт бараа материал	289.91	41.30	248.6	0.1

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 69.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 71.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, 246.1 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансаж шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 6521.1 сая төгрөг байсан бол оны эцэст 2346.9 сая төгрөг болж 4174.2 сая төгрөгөөр буурсан нь Засаг даргын тамгын газрын балансад бүртгэлтэй 76.9 сая төгрөгийн хог тээврийн авто машин, трактор, бага оврын трактор, 80.5 сая төгрөгийн өртөгтэй Борт багийн төвийн барилга байгууламжийг дуудлага худалдаагаар борлуулж данс бүртгэлээс хасаж 186.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, хандиваар, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ковш авто ачигч, Мал угаалгын ванн, отрын мэдээллийн цэг, грамм, мотоцикл гэх мэт хөрөнгүүдийг орлогод авч, 3744.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж 284.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 9.5 сая, эцсийн үлдэгдэл 12.7 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр өссөн байна. Тайлан хугацаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч тэжээл бэлтгэсэн, Гэрэл цахилгааны өглөг 0.6 сая, түлш халаалтын өглөг 2.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж балансаас балансад 9.6 сая төгрөгийн өглөг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2,353.5 сая төгрөг байснаас оны эцэст 1146.9 сая төгрөг болж 1206.6 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн баланс шилжсэнтэй холбоотой 2021 онд сумын төвөөс ховд хүртэлх сайжруулсан шороон зам орлого авч 20 жилээр элэгдэл байгуулсныг залруулан 117.9 сая төгрөгийн элэгдлийг өмнөх үеийн үр дүн рүү залруулга хийсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1213.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1213.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Мөнххайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1213.0 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны 7/02 тоот тогтоолоор нийт 1130.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 7/02 тоот тогтоолоор 1130.5 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1130.5 сая төгрөгийн төсөв баталснаас 228.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 399.5 сая төгрөг татварын болон татварын бус орлогоос, 241.3 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 62.6 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 198.6 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлжээ. Аймгийн Засаг даргын А/821 тоот захирамжаар Мөнххайрхан сумын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн тогтмол зардалд 3.5 сая төгрөгийн төсвийн нэмэлт зохицуулалт хийсэн байна.

Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Санхүүжилтийн эх үүсвэр	/сая төгрөгөөр/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын болон татварын бус орлого	399.5	413.0
Татварын орлого	396.9	409.0
Татварын бус орлого	2.6	4.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	469.7	469.7
Орон нутгийн төсвөөс	228.4	228.4
Орон нутгийн хөгжлийн сан	241.3	241.3
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	261.3	227.5
Туслах үйл ажиллагааны орлогоос	62.6	28.8
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	198.7	198.7
Засаг даргын захирамж		3.5
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	1130.5	1113.7

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 228.4, орон нутгийн татварын болон татварын бус орлого 413.0, ОХНС-ийн санхүүжилт 241.3, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, өвсний авлагаас 28.8 урьд оны үлдэгдлээс 198.7 сая төгрөг аймгийн Засаг даргын захирамжаар 3.5 сая төгрөгийг зарцуулах эрх нээлгэж нийт 1,113.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,040.2 сая төгрөгийг зарцуулж 27.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод буцаан төвлөрүүлж

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1040.2 сая төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 9.3 сая, Бараа үйлчилгээний бусад зардал 16.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 1.4 сая, байр ашиглахтай

холбоотой зардал 0.1 сая Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгоогүй, нийт 27.2 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 62.6 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 23.0 сая, хүүгийн орлого 0.5 сая, алданги 1.4 сая, өвс тэжээлийн үнэ 3.8 нийт нийт 34.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж 33.8 сая төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлого тасарч, зээлийн бичиг баримт бүрдүүлэлттэй холбоотой 0.3 сая төгрөг, өвч тэжээл худалдан авахад 1.9 сая нийт 2.3 сая төгрөгийн зардал санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	399.45	413.04	(13.6)
Нийт орлого ба тусламжийн дүн	396.84	409.00	(12.2)
Татварын орлого	396.84	409.00	(12.2)
Орлогын албан татвар	153.30	145.50	7.8
Хувь хүний орлогын албан татвар	153.30	145.50	7.80
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	118.20	133.20	(15.0)
Үйл ажиллагааны орлого	15.00	10.10	4.9
Шууд бус орлого	20.10	2.20	17.9
Херенгийн албан татвар	55.01	50.20	4.8
Үл хөдлөх эд херенгийн албан татвар	1.50	2.90	(1.4)
Бууны албан татвар	4.51	4.90	(0.4)
Малын тоо толгойн албан татвар	30.00	29.10	0.9
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	19.00	13.30	5.7
Бусад татвар, телбер, хураамж	188.53	213.30	(24.8)
Бусад нийтлэг телбер, хураамж	3.40	3.00	0.4
Улсын тэмдэгтийн хураамж	1.50	0.60	0.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	0.40	0.40	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.50	2.00	(0.5)
Газрын телбер	4.31	2.90	1.4
Газрын телбер	4.31	2.90	1.4
Дуудлага худалдаа	-	-	-
Байгалийн нөөц ашигласны телбер	180.82	207.40	(26.6)
Ан амьтны нөөц ашигласны телбер	179.55	206.00	(26.5)
Ус, рашааны нөөц ашигласны телбер	0.27	0.30	(0.0)
Байгалийн ургамлын нөөц ашигласны телбер	1.00	1.10	(0.1)
Татварын бус орлого	2.61	4.04	(1.4)
Нийтлэг татварын бус орлого	2.61	4.04	(1.4)
Хувьцааны ногдол ашиг	-	-	-
Торгуулийн орлого	2.00	3.43	(1.4)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.61	0.61	-

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 413.04 сая төгрөг буюу 13.6 сая төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь Цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр

эрхлэлтийн орлого 15.0 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.4 сая төгрөг, бууны албан татвар 0.4 сая, ан амьтан нөөц ашигласны төлбөр 26.5 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.5 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.1 сая торгуулийн орлого 1.4 сая төгрөгөөр тус тус орлого давуулан биелүүлж, хувь хүний орлогын албан тавар 7.8 сая, үйл ажиллагааны орлого 4.9 сая, шууд бус орлого 17.9 сая, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 5.7 сая, малын тоо толгойн албан татвар 0.9 сая, газрын төлбөр 1.4 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.9 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10 сая төгрөг, Шим –Ус ОНӨААТҮГ-аас 2.3 сая төгрөг, төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 1.1, байгаль хамгаалах сангаас 4.9, статистикийн хэлтсээс 0.4 сая төгрөг, ИТХ-аас хүүхэд хамгааллын багт 0.3 сая, шүлхийн дархлаажуулалтын зардал 3.1, Спортын тэмцээний шагнал 0.7 сая, аймгийн ЗДНХ-өөс 0.2 сая, ГХУСЗЗ-өөс 1.0 сая төгрөг нийт 24.0 сая төгрөгийг төвлөрүүлэн бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнххайрхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 03 дугаар сарын 17-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 1/49 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,197.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 23.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 19.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ-нь байгууллагын төсвөөс 0.3 сая төгрөгийн хэвлэл, захиалгын зардал гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт барагдаж 67.2 сая төгрөгийн 1 албан шаардлага 101.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөгөөр/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Акт	2	0.8	2	0.8	-	-
Албан шаардлага	1	67.2	1	67.2	-	-	100.0
Зөвлөмж	4	101.3	4	101.3	-	-	100.0
Нийт дүн	7	169.3	7	169.3	-	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Орон нутгийн хөгжлийн сангийн балансад бүртгэлтэй 49.9 сая төгрөгийн малжуулах төслийн зээлийн авлагын хугацаа 2023 онд дуусах гэрээтэй, мөн Сум хөгжүүлэх сангийн он дамжиж олон жил байгаа 13 зээлдэгчтэй холбоотой 67.2 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлсэн тул биелэлтүүдийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 97.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 97.7 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** ОНХС-ийн санхүүжилтээр Ёслол хүндэтгэлийн өргөө барих ажлын санхүүжилтийг олгохдоо бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 91.2 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.
- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Ковш тээвэрлэж ирсэн 6.5 сая төгрөгийн зардлыг шууд зардалд бүртгэснийг залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 52.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 52.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

- ✓ ЗДТГ-ын даргад амралт, баяр ёслолын өдрөөр ажилласан 29.2 цагийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Төрийн захиргааны болон үйлчилгээ албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3 дугаар зүйлийн 3.3 "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

5.2.1 Авлагын данстай холбоотой

Илрүүлэлт: "Сум хөгжүүлэх сангийн балансад бүртгэлтэй 12.39 сая төгрөгийн насжилт өндөртэй өвсний авлага барагдуулаагүй, няравтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : *Насажсан өвс тэжээлийн авлагыг барагдуулж тооцоо нийлж дотоод хяналт хэрэгжүүлэх*

5.2.2 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Ковш трактор худалдан авах НТШ-2022-Бараа-01 дугаартай гэрээг байгуулж баталгаат хугацаанд 5.5 сая төгрөгийн барьцаа суутгаж авалгүйгээр санхүүжилтийг 100 хувь олгосон, Ёслол хүндэтгэлийн өргөө барих ажлын НТШ-2022-Ажил-02 дугаартай гэрээ байгуулж гэрээний 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.4 дахь заалтыг зөрчин улсын комисс хүлээж аваагүй байхад 34.5 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгосон зөрчлүүд илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 43.6-д "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно" Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх хянан тайлагнах журмын 2.3.2.4-д "барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар холбогдох дүрмийн дагуу ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн санхүүжилт хүсэх" 2.3.2.5-д "барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх".

Өгсөн зөвлөмж: *Хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлж санхүүжилтийг олгох, хөрөнгө оруулалтын ажлаас барьцаа хөрөнгө суутган холбогдох дансанд шилжүүлэх, алдааг давтан гаргахгүй ажиллах*

5.2.3 Цалин хөдөлмөрийн хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгохдоо Төрийн үйлчилгээний албан хаагчдыг орхигдуулж олгодог зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2.1 Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг бүгдэн үр дүнгийн урамшууллыг холбогдох хууль журамд нийцүүлэн батлагдсан төсөвт багтаан олгох*

5.2.4 Зардлын асуудалтай холбоотой

Илрүүлэлт: ЗДТГ-аас Ховдын толь, Ховдын мэдээ сониноос хэвлэл захиалж 0.3 сая төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно 12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр, Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж хэвлэл захилгын зардал санхүүжүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Үүнээс		Зөвлөмж	
					Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Еслол хүндэтгэлийн өргөө барих ажлын санхүүжилт олгоходоо и-баримт аваагүй	1.0	91.2	1.0	91.2	1.0	91.2	-	-
Ковш тээвэрлэж ирсэн зардлыг шууд зардалд бүртгэс	1.0	6.5	1.0	6.5	1.0	6.5		
Дүн	1.0	97.7	2.0	97.7	2.0	97.7	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Ковш трактор худалдан авах НТШ-2022-Бараа-01 дугаартай гэрээг байгуулж баталгаат хугацаанд барьцаа суутгаж авалгүйгээр санхүүжилтийг 100 хувь олгосон, Еслол хүндэтгэлийн өргөө барих ажлын НТШ-2022-Ажил-02 дугаартай гэрээ байгуулж гэрээний 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.4 дахь заалтыг зөрчин улсын комисс хүлээж аваагүй байхад гэрээний үлдэгдэл санхүүжилтийг олгосон,	1	40.1			1	40.1
Хоршоо хөгжүүлэх сангийн балансад бүртгэлтэй насажсан өвсний авлага барагдуулаагүй, няравтай тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	12.4			1	12.4

ЗДТГ-ын даргад баяр ёслолын өдрөөр ажилласан 29.2 цагийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон	1	0.2	1	0.2	-	-
Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгохдоо Төрийн үйлчилгээний албан хаагчдыг орхигдуулж олгосон	1	-			1	-
Дүн	4	52.7	1	0.2	3	52.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ-аас Ховдын толь, Ховдын мэдээ сонинноос хэвлэл захиалгын зардал гаргасан	1.0	0.3	-	-	-	-	1.0	0.3
Дүн	1.0	0.3					1.0	0.3
Нийт дүн	1.0	0.3					1.0	0.3

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

С.ОЮУНЖАРГАЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 49/2170430

Ховд

ХОА-2022/08/НА-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ЗДТГ-ын даргад амралт, баяр ёслолын өдрөөр ажилласан 29.2 цагийн илүү цагийн нэмэгдэл 211.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Төрийн захиргааны болон үйлчилгээ албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3 дугаар зүйлийн 3.3 "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 211.4 мянган төгрөг / хоёр зуун арван нэгэн мянга дөрвөн зуун төгрөг/-ийг бусад нэр зааж ангилагдаагүй орлогын төрийн сан банкны 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мөнххайрхан сумын ЗДТГ-ын дарга О.Бишгарам, Б.Бадамцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН :

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

У.БОЛДБААТАР

АУДИТОР

С.ОЮУНЖАРГАЛ